



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Завсрын аудитын тайлан

Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны 3 улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



***Орон нутгийн татварын орлогын
төлөвлөгөөг дутуу биелүүлж, үйл
ажиллагааны зарим зардлыг хэтрүүлэн
зарцуулсан байна.***

2016 он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u> Говьсүмбэр аймгийн аудитын газар Аймгийн Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Аудитор Г.Наранбаяр 2016 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 БҮЛЭГ 1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 0.2 хувиар давж биелсэн боловч 10 нэр төрлийн татварын орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна. 1.1 Сангийн яамнаас баталсан орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аас 9 нэр төрлийн орлогыг 458,383.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 73,000.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна. 1.2 Орон нутгийн татварын 10 нэр төрлийн орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна. 1.3 Орон нутгийн татварын орлогын 16 дансанд нийт 34,103.8 мянган төгрөгийн залруулга хийгдсэн байна. 1.4 Аймаг, сумдын татварын орлогыг 18 нэр төрлөөр ангилж, 4 арилжааны банкинд 66 данс нээлгэсэн боловч данс нээлгэх гэрээг Сангийн сайдын баталсан үлгэрчилсэн загвараар байгуулаагүй байна. 1.5 Аймгийн Татварын хэлтэс ТЕГ-ын мэдээллийн системд татварын орлогын нэр төрлөөр мэдээллийн сан үүсгэсэн боловч 56,948.1 мянган төгрөгийн татварын орлогыг зохих журмын дагуу бүртгээгүй байна. 1.6 Орон нутгийн татварын орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй 1, 7 дугаар саруудад тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. БҮЛЭГ 2: Тус хэлтсийн үйл ажиллагаанд удирдлагын зүгээс тавих хяналт хангалтгүй байгаагаас нийт 10,854.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. 2.1. Урамшууллын болон хоолны хөнгөлөлтийн төсвийг 9,368.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. 2.2. Тус хэлтсийн дарга аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан байна.
---	---

	2.3. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 4,126.5 мянган төгрөгөөр илүү тооцсон, бараа материалын анхан шатны маягтуудыг бүрэн хөтлөөгүй байна. 2.4. Удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас НБББББ-ийг мөрдөж ажиллаагүй, албан хэрэг хөтлөлт хангалтгүй байна. 2.5. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна. Дүгнэлт Зөвлөмж
--	---

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕГ	Татварын ерөнхий газар
ХК	Хувьцаат компани
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудитын зорилго, зорилт:

Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны 3 улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд завсрын аудит хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

2. Аудитын хамрах хүрээ:

Аудитад 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, мэдээ, судалгаа, Татварын хэлтсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, бүрдүүлэлттэй холбоотой баримт материал, холбогдох бусад баримт материалыг хамрууллаа.

3. Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна ажил гүйлгээг анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

4. Үндсэн мэдээлэл:

Аймгийн Татварын хэлтэс нь татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж, хурааж, ТЕГ-аас батлагдсан үндсэн чиглэл, үйл ажиллагаа, гүйцэтгэлийн стандартын түвшинг биелүүлэх замаар нийтийн хэрэгцээг хангах гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

2016 онд МУ-ын Засгийн газраас дэвшүүлсэн татварын шинэчлэл хийх зорилтыг хэрэгжүүлэх, татварын бодлого, технологийн ажлын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилт, цахим хэрэглээний програмыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэх, татвар төлөгчдөд үйлчлэх ажиллагааг улам боловсронгуй болгож, татвар төлөгч, татварын байгууллага хоорондын харилцаанд шинэчлэл хийх гэсэн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Аймгийн Татварын хэлтэс нь 2016 онд 10 орон тоотой, 144,403.1 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар улсын төсвөөс 120,633.4 мянга, аймгийн ЗДНС-гаас 1,000.0 мянга, нийт 121633.4 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажиллаж, үйл ажиллагааны зардалд 118,844.6 мянган төгрөг зарцуулж, 2,788.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2016 тус хэлтсийн дарга 3, нягтлан бодогч 2 солигдсон байна.

Тухайлбал: Хэлтсийн даргаар

- Б.Наранбаатар 2016.01.01-ний өдрөөс 2016.03.02-ны өдөр хүртэл,
- С.Алтанцэцэг 2016.03.02-ноос 2016.09.19-ний өдөр хүртэл
- П.Энх-Оюун 2016.09.19-ний өдрөөс одоог хүртэл

Нягтлан бодогчоор

- Б.Боржигон 2016.01.01-нээс 2016.04.21-ний өдөр хүртэл,
Д.Жаргалсүрэн 2016.04.21-ний өдрөөс одоог хүртэл тус тус томилогдон ажиллаж байна.

Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор 2016 оны орон нутгийн төсөвт нийт 4,670,098.7 мянган төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөж, батлуулсан бөгөөд тайлант онд төсвийн тодотгол хийж, АИТХ-ын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолоор татварын орлогыг 135,757.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 4,330,855.9 мянган төгрөгөөр баталсан байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар орон нутгийн татварын орлогод 3,658,621.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,665,627.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогыг 6,852.1 мянган төгрөг буюу 100.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч 10 нэр төрлийн татварын орлого 0,3-53,0 хувиар тасарсан байна.

Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь хүснэгтээр харуулбал:

Татварын төрөл	2016.09.30-ны байдлаар			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сум, дүүргийн төсөв	201 941,9	204 898,1	2 956,2	1,5%
Аж ахуй эрхэлсний орлого	37 845,0	34 945,4	(2 899,6)	-7,7%
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	32 940,0	31 064,1	(1 875,9)	-5,7%
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос	50 255,0	61 533,3	11 278,3	22,4%
Бууны татвар	3 661,0	3 649,5	(11,5)	-0,3%
Улсын тэмдэгтийн хураамж	11 164,5	11 303,6	139,1	1,2%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		1 476,0	1 476,0	
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	66 076,4	60 926,2	(5 150,2)	-7,8%
Аймаг, нийслэлийн төсөв	3 456 679,4	3 460 575,3	3 895,9	0,1%
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\	2 131 270,3	2 117 613,6	(13 656,7)	-0,6%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	188 597,2	178 889,0	(9 708,2)	-5,1%

/мянган төгрөгөөр/

Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар		244,2	244,2	
Улсын тэмдэгийн хураамж	23 500,0	29 762,6	6 262,6	26,6%
Газрын төлбөр	71 000,0	83 609,5	12 609,5	17,8%
Усны нөөц ашигласны төлбөр	680 919,9	631 831,6	(49 088,3)	-7,2%
Түрээсийн орлого	47 000,0	30 878,5	(16 121,5)	-34,3%
Татварын хүү торгуулийн орлого	18 200,0	8 552,0	(9 648,0)	-53,0%
Татварын бус хүү торгуулийн орлого	189 578,0	277 162,7	87 584,7	46,2%
Дуудлага худалдааны орлого	16 220,0	19 920,0	3 700,0	22,8%
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	90 394,0	82 111,7	(8 282,3)	-9,2%
НИЙТ ДҮН	3 658 621,3	3 665 473,4	6 852,1	0,2%

Говьсүмбэр аймгийн орон нутгийн татварын орлогыг бүрэн төвлөрүүлж, үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэх

Бүлэг 1

Орон нутгийн татварын 10 нэр төрлийн орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна.

1.1 Сангийн яамнаас баталсан орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аас нэмэгдүүлэн баталсан байна.

Говьсүмбэр аймгийн 2016 оны орон нутгийн татварын орлого Сангийн яамнаас 4,376,702.9 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолоор 2016 оны төсвийг хэлэлцэхдээ орлогыг 293,356.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 4,670,059.3 мянган төгрөгөөр баталсан байна.

2016 онд аймгийн ИТХ-аас 2016 оны төсөвт 2 удаа тодотгол хийж, татварын орлогыг 92,027.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 4,762,086.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний өөрчлөлтийг нэр төрлөөр харуулбал:

Татварын төрөл	/мянган төгрөгөөр/					
	2016 оны төлөвлөгөө /Сангийн яам баталсан/	2016 оны төлөвлөгөө /ИТХ-аар баталсан/	Тодотгол-1 /2016.08.18/	Тодотгол-2 /2016.09.29/	Тодотголоор өөрчлөгдсөн зөрүү	Хувь
Сум, дүүргийн төсөв	310 363,8	291 742,8	291 742,8	255 989,2	(35 753,6)	0,12
Аж ахуй эрхэлсний орлого	50 536,3	50 536,3	50 536,3	50 536,3	-	-
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	84 000,0	44 000,0	44 000,0	44 000,0	-	-
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос	90 000,0	90 000,0	90 000,0	57 000,0	(33 000,0)	0,37
Бууны татвар	577,5	4 816,5	4 816,5	4 816,5	-	-
Улсын тэмдэгийн хураамж	14 900,0	14 900,0	14 900,0	14 900,0	-	-
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	-	-	-	-	-	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	70 350,0	87 490,0	87 490,0	84 736,4	(2 753,6)	0,03
Аймаг, нийслэлийн төсөв	4 066 339,1	4 378 316,5	4 446 812,7	4 506 097,2	127 780,7	(0,03)
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\	2 807 550,2	2 827 574,6	2 827 574,6	2 862 574,6	35 000,0	(0,01)

Үл хөдлөх хөрөнгийн татвар	210 000,0	240 000,0	240 000,0	240 000,0	-	-
Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар	-	-	-	-	-	-
Улсын тэмдэгтийн хураамж	35 500,0	35 500,0	35 500,0	35 500,0	-	-
Газрын төлбөр	89 250,0	89 250,0	89 250,0	89 250,0	-	-
Усны нөөц ашигласны төлбөр	693 469,9	793 469,9	820 746,1	820 746,1	27 276,2	(0,03)
Түрээсийн орлого	36 750,0	71 750,0	71 750,0	71 750,0	-	-
Татварын хүү торгуулийн орлого		35 000,0	35 000,0	35 000,0	-	-
Татварын бус хүү торгуулийн орлого	103 425,0	195 378,0	220 378,0	244 662,5	49 284,5	(0,25)
Дуудлага худалдааны орлого			16 220,0	16 220,0	16 220,0	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	90 394,0	90 394,0	90 394,0	90 394,0	-	-
НИЙТ ДҮН	4 376 702,9	4 670 059,3	4 738 555,5	4 762 086,4	92 027,1	(0,02)

Хүснэгтээс харахад: Сангийн яамнаас батлагдсан орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 8.8 хувиар, тайлант онд хийгдсэн 2 удаагийн төсвийн тодотголоор 1.5-1.9 хувиар тус тус нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал: аймгийн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 2.9 хувь буюу 127,780.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сумдын орон нутгийн орлогын төлөвлөгөөг 12.2 хувь буюу 35,753.6 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Сангийн яамнаас баталсан татварын орлогын төлөвлөгөөнд аймгийн ИТХ-аас тодотгол хийхдээ 9 нэр төрлийн орлогыг 458,383.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 73,000.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Нэмэгдүүлэн баталсан татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогыг 55,024.4 мянга,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 30,000.0 мянга,
- Усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 127,276.2 мянга,
- Түрээсийн орлогыг 35,000.0 мянга,
- Татварын хүү торгуулийн орлогыг 35,000.0 мянга,
- Татварын бус хүү торгуулийн орлогыг 141,237.5 мянга,
- Дуудлага худалдааны орлогыг 16,220.0 мянга,
- Бууны албан татварын орлогыг 4,239.0 мянга,
- Сумдын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 14,386.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Харин орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 73,000.0 мянган төгрөгөөр бууруулсан бөгөөд нэр төрлөөр нь харуулбал:

- Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татварын орлогыг арилжааны банкуудын ипотекийн зээлийн журамд өөрчлөлт орсон болон эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан хөдлөх хөрөнгө худалдан авах эрэлт эрс буурсантай холбоотойгоор 40,000.0 мянга,
- Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгах албан татварын орлогын төлөвлөгөө эхний хагас жилд тасарсан шалтгаанаар 33,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулан баталсан байна.

Тайлант онд төсвийн тодотголоор орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэн баталсан нь:

- Бууны албан татварын орлогыг татварын хувь хэмжээ нэмэгдсэнийг тооцолгүй өмнөх оны гүйцэтгэлээр батлуулсныг нэмэгдүүлсэн,
- Баянтал, Шивээговь сумын ИТХ-д иргэний танхимын ажилтны орон тоог нэмж батлан, ажилтны цалингийн зардалд зарцуулах зорилгоор Хог, хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлсэн,
- 2016 онд дуудлага худалдааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд тайлант онд төсөвт байгууллагуудын акталсан үндсэн хөрөнгийг худалдсан дуудлага худалдааны орлогын хэмжээгээр,
- Аймгийн Аудитын газар, МХГ, Цагдаагийн хэлтсийн торгууль, төсвийн байгууллагуудын арга хэмжээний суутгал зэрэг татварын бус хүү, торгуулийн орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогын хэмжээгээр,
- Шивээ-Овоо” ХК-ийн усны нөөц ашигласны төлбөрийн өмнөх оны дутуу төлөгдсөн үлдэгдэл он дамжин төлөгдсөнөөс тус тус шалтгаалсан байна.

Дээрх байдлаас харахад тайлант онд төлөвлөсөн орлогуудыг бүрэн төвлөрүүлдэггүйгээс он дамжин төлөгддөг, орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэл, бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр дутуу батлуулсанаас орлогын төлөвлөгөө давж биелсэн мэт харагдаж байна.

Иймд орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг тухайн жилд бүрдүүлэх боломжтой эсэхийг бүрэн тооцож бодит тоон мэдээнд үндэслэн батлуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2 Орон нутгийн татварын 10 нэр төрлийн орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар орон нутгийн татварын орлогод 3,658,621.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 3,665,627.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогыг 6,852.1 мянган төгрөг буюу 100.2 хувиар давуулан биелүүлсэн байна.

Татварын орлого нийт дүнгээрээ биелсэн боловч нэр төрлөөрөө тасарсан байна.

Орон нутгийн татварын орлогын 2016 оны 3 дугаар улирлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр харуулбал:

/мянган төгрөгөөр/

Татварын төрөл	2016.09.30-ны байдлаар			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Сум, дүүргийн төсөв	201 941,9	204 898,1	2 956,2	1,5%
Аж ахуй эрхэлсний орлого	37 845,0	34 945,4	(2 899,6)	-7,7%
Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	32 940,0	31 064,1	(1 875,9)	-5,7%
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос	50 255,0	61 533,3	11 278,3	22,4%

Бууны татвар	3 661,0	3 649,5	(11,5)	-0,3%
Улсын тэмдэгтийн хураамж	11 164,5	11 303,6	139,1	1,2%
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр		1 476,0	1 476,0	
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	66 076,4	60 926,2	(5 150,2)	-7,8%
Аймаг, нийслэлийн төсөв	3 456 679,4	3 460 575,3	3 895,9	0,1%
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого \Суутган-1\	2 131 270,3	2 117 613,6	(13 656,7)	-0,6%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	188 597,2	178 889,0	(9 708,2)	-5,1%
Газрын үл хөдлөх хөрөнгийн албан татвар		244,2	244,2	
Улсын тэмдэгтийн хураамж	23 500,0	29 762,6	6 262,6	26,6%
Газрын төлбөр	71 000,0	83 609,5	12 609,5	17,8%
Усны нөөц ашигласны төлбөр	680 919,9	631 831,6	(49 088,3)	-7,2%
Түрээсийн орлого	47 000,0	30 878,5	(16 121,5)	-34,3%
Татварын хүү торгуулийн орлого	18 200,0	8 552,0	(9 648,0)	-53,0%
Татварын бус хүү торгуулийн орлого	189 578,0	277 162,7	87 584,7	46,2%
Дуудлага худалдааны орлого	16 220,0	19 920,0	3 700,0	22,8%
Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар	90 394,0	82 111,7	(8 282,3)	-9,2%
НИЙТ ДҮН	3 658 621,3	3 665 473,4	6 852,1	0,2%

Хүснэгтээс харахад: 6 нэр төрлийн орлого 1.2-46.2 хувиар давж биелсэн бол 10 нэр төрлийн орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна. Тухайлбал:

Давж биелсэн орлогыг нэр төрлөөр нь харуулбал:

- ✓ СХХООСАТатвар 11,278.3 мянга буюу 22.4 хувь
- ✓ Улсын тэмдэгтийн хураамж 1.2 хувь
- ✓ Улсын тэмдэгтийн хураамж 26.6 хувь
- ✓ Газрын төлбөр 17.8 хувь
- ✓ Татварын бус хүү торгуулийн орлого 46.2 хувь
- ✓ Дуудлага худалдааны орлого 22.8 хувиар тус тус давж биелсэн байна.

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 0.1 хувиар давж биелсэн боловч татварын орлогын нэр төрлөөрөө тасарсан нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

- ✓ Бууны албан татвар – уг татварыг төлөх хуулийн хугацаа болоогүйгээс 11.5 мянга буюу 0.3 хувиар,
- ✓ Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар - ҮХХАТ нь орон сууц худалдан авах ипотекийн зээлд өөрчлөлт орсноор үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт буурснаас 1,875.9 мянга буюу 5.7 хувиар
- ✓ Аж ахуй эрхэлсний орлого - 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс ОТБТБАҮХЭИОАТ-ын хууль хүчингүй болж, ХХОАТ-ын хуулийн дагуу цэвэр ашгийн 10%-аар татвар төлдөг болсонтой холбоотой аж ахуйн эрхэлсэний орлого буурсан 2,899.6 мянган буюу 7.7 хувиар
- ✓ Хог хаягдлын үйлчилгээний хураамж – Баянтал, Шивээговь сумдын хог хаягдлын хураамжийг 5,150.2 мянга буюу 7.8 хувь
- ✓ Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлого - Төсөвт байгууллагууд цаг тухай бүрд нь татвараа шилжүүлээгүйгээс ХХОАТ-ын өглөг үүссэн 13 656,7 мянга буюу 0.6 хувиар
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн татвар - “Шивээ-Овоо” ХК үл хөдлөх хөрөнгийн татварын дутуу төлсөн 9,708.2 татвар 5.1 хувиар

- ✓ Усны нөөц ашигласны төлбөр - “Шивээ-Овоо” ХК үл хөдлөх хөрөнгийн татвар болон усны нөөц ашигласны төлбөрөө дутуу төлсөн 49,088.3 мянга буюу 7.2 хувиар
- ✓ Түрээсийн орлого - ОНӨА гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс 16,121.5 мянган буюу 34.3 хувиар
- ✓ Татварын хүү торгуулийн орлого - Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль хэрэгжсэнээс 9,648.0 мянга буюу 53.0 хувиар
- ✓ Автотээвэр, өөрөө явагч хэрэгслийн татвар - АТБӨЯХАТ-ыг өмнөх оны гүйцэтгэлээр төлөвлөсөнөөс 2016 онд гадны дугаартай тээврийн хэрэгсэл оношлогоонд хамрагдаагүй, АТҮТ-д бүртгэлтэй боловч сүүлийн 2 жил хөдөлгөөнд оролцоогүй болон хөдөлгөөнд оролцох боломжгүй болсон тээврийн хэрэгслийн албан татварыг тооцож хуулийн дагуу бүрэн төвлөрүүлээгүйгээс 8,282.3 мянга буюу 9.2 хувиар тус тус тасарсан байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар түрээсийн орлого 48,404.4 мянган төгрөг төвлөрүүлэхээс 31,214.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 17,190.1 мянган төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.

Түрээсийн орлогын төлөвлөгөөг аймгийн ОНӨА-наас ААНБ, иргэдтэй байгуулсан гэрээг үндэслэн баталсан бөгөөд ОНӨА гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан байна.

2016 онд аймгийн ОНӨА-наас 21 иргэнтэй орон сууц түрээслүүлэх, 23 аж ахуйн нэгж байгууллагатай албан байр түрээслүүлэх гэрээг тус тус байгуулсан байна.

АТБӨЯХАТ-т өмнөх оны гүйцэтгэлээр 95,241.7 мянган төгрөг төвлөрсөнөөс 23.8 хувь 22,671.1 мянган төгрөг нь гадны дугаартай тээврийн хэрэгслийн албан татвар байна.

Татварын хэлтсээс аймгийн Засаг даргын 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/105 дугаар захирамж, 2016 оны 08 дугаар сард аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийг үндэслэн “АТБӨЯХАТ, АТБӨЯХ-ийн техник хяналтын үзлэг, албан татварт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг татвар, техникийн хяналтын үзлэгт хамруулах, хуулийн хэрэгжилтийг хангуулах” ажлыг аймгийн ЗЦГ, Автотээврийн үндэсний төвтэй хамтран 2 удаа зохион байгуулсан байна. Тухайн үед АТҮТ-ийн програм дахь бүртгэл, тээврийн хэрэгслийн гэрчилгээтэй зөрөх, ижил улсын дугаартай тээврийн хэрэгсэл байсныг залруулж ажилласан байна.

Мөн АТҮТ-д бүртгэлтэй боловч сүүлийн 2 жил хөдөлгөөнд оролцоогүй болон хөдөлгөөнд оролцох боломжгүй болсон 572 тээврийн хэрэгслийн судалгааг 2016 оны хагас жилийн байдлаар гаргасан байна.

Уг судалгаагаар тээврийн хэрэгслийн албан татварт 26,294.9 мянга, агаарын бохирдлын төлбөрт 2,397.5 мянга, нийт 28,692.4 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр ногдол хийгдсэн боловч татварыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

Харин Татварын хэлтэс болон Говьсүмбэр аймгийн Автотээврийн төвд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо 119-өөр зөрүүтэй байна. Тухайлбал, Татварын хэлтэст нийт 3,038 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй бол аймгийн Автотээврийн төвд 3,157 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна.

Иймд тээврийн хэрэгслийн тоог АТҮТ-тэй тулган баталгаажуулах, бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийг бүртгэх, АТҮТ-д бүртгэлтэй боловч сүүлийн 2 жил хөдөлгөөнд оролцоогүй болон хөдөлгөөнд оролцох боломжгүй болсон 572 тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасагдаагүй тохиолдолд татварыг ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, татварыг бүрэн төлүүлсний дараа бүртгэлээс хасах, холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой, хамтран ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.3 Орлогын дансдын залруулгыг цаг тухай бүрд хийгээгүйгээс 56,948.1 мянган төгрөгийн орлогыг буруу бүртгэж, мэдээлсэн, 24,368.2 мянган төгрөгийн залруулгын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй байна.

2016 оны 3 дугаар улирлын байдлаар орон нутгийн татварын орлогын 16 дансанд нийт 22,153.5 мянган төгрөгийн залруулгын, 11,950.2 мянган төгрөгийн буцаан олголтын гүйлгээ тус тус хийгдсэн байна. Тухайлбал:

- Улсын тэмдэгтийн хураамжийн данснаас шүүхийн шийдвэрээр буцаан олголтын 2,516.9 мянга, залруулгын 1,695.2 мянга,
- Дуудлага худалдааны дэнчин буцаан олгосон 7,220.0 мянга,
- Татварын орлогыг тухайн татвар төлөгч иргэд, ААНБ-ууд данс андуурч тушаасан, арилжааны банкны теллер дансандуурч төвлөрүүлсэн 20,458.3 мянга,
- ААНБ-аас давхардуулан төлсөн татаврын 2,213.3 мянган төгрөгийн буцаан олголтын гүйлгээ тус тус хийгдсэн байна.

Орлогын дансны залруулгыг “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-д заансы дагуу залруулга хийлгэх болон буцаалт хийх тухай хүсэлтийг ААНБ-ын албан бичиг, иргэдийн өргөдлийг үндэслэн холбогдох баримт материалыг бүрдүүлж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр хүргүүлдэг боловч аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс залруулга хийгдсэн эсэх талаар албан ёсны хариу ирүүлдэггүй байна.

Мөн Иргэний орлогын албан татварын 1,263.5 мянган төгрөгийн орлогыг татвар хураагчийн нэрээр, 126.6 мянган төгрөгийн орлогыг Төрийн банкны нэрээр, газрын төлбөрийн орлогын 8 гүйлгээний 55,558.0 мянган төгрөгийг ААНБ, иргэнээр

салгаж бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэсэнээс нийт 56,948.1 мянган төгрөгийн орлогыг залруулаагүй байна.

2016 оны эхний хагас жилд хийгдсэн орлогын дансдын залруулгын болон буцаалтын 24,368.2 мянган төгрөгийн баримт материалыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгийн хамт хүргүүлсэн боловч тус хэлтэст эдийн засагчийн тодорхойлолтоос өөр баримт материал байхгүй, явуулсан бичигт албан бичгийн хавсралт материалуудыг хавсаргаагүй байна.

Орлогын дансны залруулгыг хийхдээ “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-д заасны дагуу бүх залруулгын баримтад татварын тооцооллын үлдэгдлийн баримтыг бүрдүүлэх ёстой боловч уг баримтыг бүрдүүлээгүй байна.

Харин 2016 оны 07 дугаар сараас эхлэн орлогын дансны залруулга болон буцаан олголт хийх баримтуудыг бүрдүүлж, Санхүү, төрийн сангийн албан бичгээр хүргүүлэхдээ баримт материалыг 2 хувь үйлдэж, үлдэх хувийг байгууллагад хадгалсан байна.

1.4 Сангийн сайдын баталсан үлгэрчилсэн гэрээний дагуу арилжааны банкуудад татварын орлогын дансдыг нээгээгүй байна.

Аймгийн Татварын хэлтэс нь ТЕГ-ын даргын 2016 оны А/186 дугаар тушаалаар батлагдсан “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-ын дагуу татварын нэр, төрөл бүрээр Төрийн сан болон арилжааны банкуудад данс нээлгэсэн бөгөөд арилжааны банкин дахь тухайн татварын орлогын дансны өдөр тутмын орлогыг Төрийн сан дахь дансанд төвлөрүүлэхээр журамлагдсан байна.

Аймгийн хэмжээнд орон нутгийн татварын орлогыг төвлөрүүлэх Төрийн сангийн 40, арилжааны банкуудад “0” үлдэгдэлтэй 66 данс нээлгэсэн байна.

Төрийн сангийн дансанд өдөр бүрийн татварын орлогыг төвлөрүүлдэг аймгийн орон нутгийн орлогын 15, сумдын орон нутгийн татварын орлогын 25 данс байна.

Харин арилжааны банкинд нээлгэсэн 66 данснаас Хаан банкинд 22, Төрийн банкинд 22, Хас банкинд 12, Капитал банкинд 10 данс тус тус байна.

2016 оны 03 дугаар улирлын байдлаар арилжааны банкин дахь 10 дансаар огт гүйлгээ хийгдээгүй байна. Үүнд:

- Хаан банкны 4 данс
- Төрийн банкны 1 данс
- Хас банкны 1 данс
- Капитал банкны 4 данс

Арилжааны банкуудад татварын орлогын дансдыг нээхдээ Сангийн сайдын баталсан Арилжааны банкны гурван талт “Арилжааны банкинд төсвийн орлогын

“ТЭГ” үлдэгдэлтэй дансдыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ”-ний загвараар байгуулаагүй байна. Тухайлбал,

- Гэрээ байгуулах албан хүсэлтийг арилжааны банкинд хүргүүлсэн боловч албан бичигт гэрээний загвар болон орлогын дансдын жагсаалтыг хавсаргаагүй,
- Гэрээнд татварын нэр төрөл тодорхойгүй, зөвхөн дансны дугаар бичигдсэн,
- Гэрээг байгуулахдаа хувь хүмүүсийн гэрээтэй адил харилцах дансаар дамжуулан төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх гэрээ, харилцах болон хугацаагүй хадгаламжийн гэрээ, харилцах дансны гэрээ, байгууллагын харилцах данс, хугацаагүй хадгаламжийн гэрээ гэх мэт банк тус бүр өөр өөр нэрээр байгуулсан,
- Татварын орлогын дансдыг нэр төрлөөр нь нээх ётой байтал байгууллагын нэрээр нээсэн, Тухайлбал: УТХ-ын дансыг аймгийн Сум дундын Шүүх, ЗДТГ, Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, ШШГА, БОАЖГ гэсэн байгууллага тус бүрээр нээсэн,
- Гэрээ нь 2 талын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй, зөвхөн банкны ахлах теллер гарын үсэг зурсан байна.

Мөн Татварын орлогын нэр төрөл бүрээр арилжааны банкинд “0” үлдэгдэлтэй данс нээлгэж, татварын орлогыг өдөр бүр төвлөрүүлэх тухай журамд заасан боловч 2016 оны эхэнд “Хас” банкны ХХОАТ-ын дансанд 220.8 мянга, НӨАТ-ын дансанд 100.0 мянга, нийт 320.8 мянган төгрөг он дамжин үлдэгдэлтэй гарсан байна.

Энэ нь ТЕГ-ын даргын 2016 оны А/186 дугаар тушаалаар батлагдсан “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-т “Арилжааны банкууд нь Татварын ерөнхий хууль, Төрийн сангийн газар, Татварын ерөнхий газар, Арилжааны банкны гурван талт “Арилжааны банкинд улсын төсвийн орлогын “0” үлдэгдэлтэй дансыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ”-нд заасны дагуу татварын орлогын дансанд төвлөрсөн мөнгөн хөрөнгийг өдөр бүр Төрийн сангийн хаалтын дансанд шилжүүлнэ” гэснийг зөрчсөн байна.

Арилжааны банкуудад хэтэрхий олон нэр төрлөөр орлогын дансдыг нээснээс Төрийн сангийн дансанд тухай бүр төвлөрүүлэх орлого сар дамжин төлөгдөх, замд яваа мөнгөн хөрөнгөөр бүртгэгдэж, орлого дутуу төвлөрөх зэргээр орлогын төлөвлөгөөний биелэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Иймд Сангийн сайдын баталсан Арилжааны банкны гурван талт “Арилжааны банкинд төсвийн орлогын “ТЭГ” үлдэгдэлтэй дансдыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ”-ний загварын дагуу арилжааны банкуудтай гэрээг шинэчлэн байгуулах, татварын орлогын “0” үлдэгдэлтэй дансдын нэр төрлийг цөөрүүлэх, холбогдох журмын дагуу өдөр тутмын орлогыг хаалтын дансанд төвлөрүүлж байх, шаардлагагүй дансдыг хааж, цэгцлэх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.5 Татварын мэдээллийн санд 56,948.1 мянган төгрөгийн татварын орлогыг нэр төрлөөр нь зохих журмын дагуу бүртгээгүй байна.

ТЕГ-ын мэдээллийн бааз нь 2 програмтай бөгөөд аймгийн нэр бүхий цэс үүсгэн TaxAct програмд иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг, TaxPayment програмд дансны орлогын мэдээллийг бүртгэсэн байна.

Тус хэлтсийн эдийн засагч орон нутгийн татварын орлогыг “0” үлдэгдэлтэй дансны хуулгыг боловсруулж, ТЕГ-ын мэдээллийн системд татварын орлогын мэдээллүүдийг оруулж байна.

Татварын орлогын програмд ХХОАТ-ын хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор аж ахуй эрхэлсний орлогод Иргэний орлогын албан татвар, хөрөнгө борлуулсны орлогын албан татварын орлогуудыг бүртгэсэн байна.

Мөн татварын орлогын Taxpayment програмд орон нутгийн орлогын мэдээллийг оруулахдаа Иргэний орлогын албан татварын 1,263.5 мянган төгрөгийн орлогыг татвар хураагчийн нэрээр, 126.6 мянган төгрөгийн орлогыг төрийн банкны нэрээр, газрын төлбөрийн 8 гүйлгээний 55,558,0 мянган төгрөгийн орлогыг бөөн дүнгээр нь тус тус бүртгэсэн байна.

Энэ нь Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа, тодорхой эрх бүхий, эсхүл ажил үйлчилгээ эрхэлж, түүнчлэн газар, түүний хэвлий, байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц ашигласан, агаар, ус, хөрс бохирдуулснаас татвар төлөх үүрэг хүлээсэн хувь хүн, хуулийн этгээд татвар төлөгч байна”, 12.2-т “Тухайн төрлийн татварын хуулиар уг татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг нарийвчлан тогтооно, ТЕГ-ын даргын 2016 оны А/186 дугаар тушаалаар батлагдсан “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5-д “Татварын орлогын баримтыг үндэслэн татварын данс тус бүрээр ангилан, татвар төлөгч, татварын төрөл, баримтын огноогоор “Татварын орлогын нэгдсэн сан”-д татварын орлогыг бүртгэнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд татварын орлогын мэдээллийг програмд оруулахдаа татварын нэр төрлийн ангилал, татвар төлөгчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

1.6 Орон нутгийн татварын орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй 1, 7 дугаар саруудад тооцоо нийлж баталгаажуулаагүй, сар бүрийн орлогын мэдээ зөрүүтэй байна.

Аймгийн Татварын хэлтсээс улсын төсвийн орлогыг ТЕГ-ын Орлогын газартай, орон нутгийн татварын орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй дараа сарын 05-ны дотор тус тус тооцоо нийлэн баталгаажуулах ёстой боловч

аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй 1, 7 дугаар саруудад орон нутгийн орлогын гүйцэтгэлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Тухайлбал: 1 дүгээр сард Татварын хэлтсийн эдийн засагч солигдсон, 7 дугаар сард аймгийн Ерөнхий санхүүч ээлжийн амралттай байсан шалтгаанаар тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Аймгийн Татварын хэлтсийн сар бүрийн орлогын мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэстэй тооцоо нийлсэн орлогын мэдээтэй тулган баталгаажуулахад 2016 оны 3 дугаар улирлын байдлаар сар бүрийн татварын орлогыг тухай бүрт нь залруулаагүйгээс 37,929.2 мянган төгрөгөөр илүү, 26,690.2 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.

Мөн аймгийн Цэргийн штабын цэргийн алба дүйцүүлэн хаах орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс хүү, торгуулийн дансанд орлогоор бүртгэснээс орлогын мэдээ уг дүнгээр зөрүүтэй байна. Энэ нь уг орлогын 50 хувийг жилийн эцэст улсын төсөвт төвлөрүүлж, 50 хувийг Цэргийн штабын үйл ажиллагаанд зарцуулдагтай холбоотой байна.

Энэ нь ТЕГ-ын даргын 2016 оны А/186 дугаар тушаалаар батлагдсан “Татварын орлогын бүртгэл, хяналтын журам”-ын 7 дугаар зүйлийн 7.3-т “Сар бүрийн татварын орлогын гүйцэтгэлийг дараа сарын 5-ны дотор тухайн шатны Төрийн сантай тооцоо нийлэн, баталгаажуулах ажлыг дараах төсвийн шатлалаар хийнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд татварын орлогыг сар бүр тооцоо нийлж баталгаажуулах зөвлөмж өгөхөр шийдвэрлэлээ.

Татварын хэлтсийн 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнтэй эсэх

Бүлэг 2

Батлагдсан төсвийг хэтрүүлэн зориулалт бусаар 6,130.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.1 Ур чадварын нэмэгдлийг хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дүгнээгүй, үндэслэлгүй тушаал гаргаж хавтгайруулан олгосон байна.

Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны төсөв 153,444.9 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд тайланд онд төсөвт 2 удаа өөрчлөлт орж, 9,396.6 мянган төгрөгөөр бууруулан 144,048.3 мянган төгрөгөөр батлагдсан байна.

Тус хэлтсийн батлагдсан төсвийг 2016 оны 3 дугаар улирлын байдлаар оны эхнээс 2 удаа өөрчилж нийт 6,736.7 төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Урамшууллын зардлыг 6,307.2 мянга, бараа үйлчилгээний зардлыг 1,491.4 мянган төгрөгөөр тус тус бууруулж, үндсэн цалинг 13,442.3 мянга, хоолны хөнгөлөлтийг

95.2 мянга, бараа үйлчилгээний зардлыг 957.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Аймгийн Татварын хэлтсийн төсвийн тодотгол, төсвийн гүйцэтгэлийн судалгааг 2016 оны 3 дугаар улирлын байдлаар харуулбал:

Зардлын зүйл анги	Батлагдсан төсөв	Тодотгол		Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Төсвийн хэтрэлт, хэмнэлт
		Нэмэгдсэн	Хасагдсан			
Төсвийн урсгал санхүүжилт	114 129 800,0	6 736 700,0		120 866 500,0	120 633 400,0	233 100,0
<i>Орлогын дүн</i>	114 129 800,0	6 736 700,0	-	120 866 500,0	120 633 400,0	233 100,0
1. Цалин хөлс, нэмэгдэл урамшил	74 483 100,0	13 537 500,0	6 307 200,0	81 713 400,0	81 713 400,0	-
Үндсэн цалин	62 199 900,0	13 442 300,0		75 642 200,0	66 273 647,0	9 368 553,0
Хоол, унааны хөнгөлөлт	2 822 400,0	95 200,0		2 917 600,0	5 559 000,0	(2 641 400,0)
Урамшуулал	9 460 800,0		6 307 200,0	3 153 600,0	9 880 753,0	(6 727 153,0)
2. Ажил олгогчоос төлөх НДШ	8 193 600,0	40 300,0		8 233 900,0	8 233 900,0	-
3. Бараа үйлчилгээний бусад зардал	31 453 100,0	957 500,0	1 491 400,0	30 919 200,0	27 897 331,0	3 021 869,0
Гэрэл цахилгаан	2 309 400,0	-	-	2 309 400,0	2 190 763,0	118 637,0
Түлш халаалт	4 187 600,0	314 000,0		4 501 600,0	2 402 400,0	2 099 200,0
Цэвэр бохир ус	551 700,0	100,0		551 800,0	467 280,8	84 519,2
Байрны түрээс	3 187 800,0		100,0	3 187 700,0	3 013 500,0	174 200,0
Эм, вакцин		-	-			-
Бичиг хэргийн зардал	1 348 200,0	386 300,0		1 734 500,0	1 754 620,0	(20 120,0)
Тээвэр шатахуун	1 778 400,0		41 900,0	1 736 500,0	1 736 500,0	-
Шуудан, харилцаа холбоо	3 666 600,0		157 000,0	3 509 600,0	3 413 068,2	96 531,8
Дотоод албан томилолт	1 487 700,0		148 000,0	1 339 700,0	1 331 950,0	7 750,0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	603 900,0		15 000,0	588 900,0	683 200,0	(94 300,0)
Хичээл практик	588 900,0		218 900,0	370 000,0	432 000,0	(62 000,0)
Холбоо суваг	10 199 700,0		891 600,0	9 308 100,0	9 075 000,0	233 100,0
Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	772 800,0		18 900,0	753 900,0	736 000,0	17 900,0
Төлбөр хураамж, бусад	770 400,0	257 100,0		1 027 500,0	661 049,0	366 451,0
Нийт зардлын дүн	114 129 800,0	14 535 300,0	7 798 600,0	120 866 500,0	117 844 631,0	3 021 869,0

Хүснэгтээс харахад 2016 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүжилт 233.1 мянган төгрөгөөр дутуу олгогдсон нь Сангийн яамнаас зарцуулах эрх нээгдээгүйтэй холбоотой бөгөөд тус байгууллагын тогтмол зардал 2,746.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 312.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдэж харилцах дансны үлдэгдэл 2,788.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Зарцуулалтын хувьд:

- Үндсэн цалингийн зардлын хэмнэлтийг хоол, унааны хөнгөлөлт, урамшууллын зардалд зарцуулж батлагдсан төсвийг хэтрүүлсэн
- Бусад зардлын хэмнэлтийг бичиг хэргийн болон хог хаягдлын зардал, хичээл практикийн зардалд тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны 3 дугаар улирлын байдлаарх төсвийн зарцуулалт, анхан шатны баримтын бүрдэл болон цалингийн тооцооллыг шалгахад дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Тус хэлтсийн даргаар ажиллаж байсан Б.Наранбаатарт 452.5 мянган төгрөгийн цалинг дутуу олгосон боловч тайлан тэнцэлд өглөгөөр тусгаагүй,

- Мөн Б.Наранбаатарт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 1 сарын урамшуулал 215,6 мянган төгрөг олгосон,
- Сумдад ажилласан ажилтнуудад томилолтын хуудасгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр томилолтын зардалд 300.0 мянга, байрны зардлыг 61.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон,
- Тайлант оны төсөв нэмж батлагдаагүй байхад ажиллагсдад хоолны мөнгийг 1.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тооцож, батлагдсан төсвийг 2,764.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
- Ур чадварын нэмэгдлийн төсөв батлагдаагүй байхад төрийн захиргааны албан тушаалын орон тоонд түр томилогдон ажиллаж байгаа хуулийн зөвлөх, хураагч нарт Татварын хэлтсийн даргын 2015 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг үндэслэн ур чадварын нэмэгдэл сар бүр олгосон байна.
- Ур чадварын нэмэгдлийг олгохдоо орлогын төлөвлөгөө тасарсан, үндсэн ажил үүргийн биелэлт хангалтгүй байхад хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлтэй уялдуулан ажлыг дүгнэлгүйгээр үндэслэлгүй тушаал гаргаж, ур чадварын нэмэгдлийг хавтгайруулан олгосноос урамшууллын зардлын батлагдсан төсөв 3,366.2 мянган төгрөгөөр хэтэрсэн байна. Тухайлбал: Хуулийн зөвлөх байгууллагын даргын тушаалын үндэслэлийг хянаж ажиллаагүйгээс 2016 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 48 “А” тушаал гарсанаас 11 тушаал хууль эрхийн үндэслэл буруу, утга найруулга алдагдсан, огноо зөрүүтэй, татварын байцаагч, хураагч нар орлогын төлөвлөгөөний биелэлтэд анхаарч ажиллаагүйгээс татварын орлогын төлөвлөгөө сар бүр тасарсан байна.

Дээрх зөрчил дутагдлууд нь дараахь хууль эрхийн актуудыг зөрчсөн байна.

Үүнд:

- Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-т “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”,
- НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 14.4.3-т “бүх өр төлбөр”-ийг заавал бүртгэнэ,
- Засгийн газрын 1995 оны 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.12-т “Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг албан томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан байр, уналгын хөлс төлсөн баримтыг бүрдүүлсний үндсэн дээр хийж дуусгана”,
- Сангийн сайдын 2011 оны 132 дугаар тушаалын 2-т “Төрийн тусгай болон үйлчилгээний албан хаагчийн хувьд байрны зардлыг зочид буудалд байрласан баримтыг үндэслэн зам хоног, байрны зардлын нийт дүн нь улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зардлын нийт хэмжээнээс хэтрэхгүй байхаар тооцож олгохыг төрийн болон

төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсвөөс санхүүждэг байгууллагуудын эрх баригч нарт зөвшөөрсүгэй”,

- Татварын хэлтсийн даргын 2015 оны А/14 дүгээр тушаалаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.11-т “Тухай жилийн төсөвт багтаан нийтийн тээврийн унааны болон хоолны мөнгийг сар бүр албан хаагчид олгоно. Унаа, хоолны зардлын хэмжээг зах зээлийн жишгийг харгалзан тухайн татварын албаны дарга тогтоож, өөрчилнө” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй олгосон 215.6 мянган төгрөгийн урамшуулал, анхан шатны баримтын бүрдэлгүй, илүү тооцож олгосон томилолтын зардал 361.5 мянга, нийт 577.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан 6,130.7 мянган төгрөгийн зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгч, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, хөрөнгийн болон урсгал шинжтэй үйл ажиллагаанд зарцуулахгүй байх тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.2 Тус хэлтсийн дарга аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан байна.

Аймгийн Татварын хэлтсийн дарга 2016 оны 04 дүгээр сарын 18-нд аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулсан бөгөөд жилийн эцэст дүгнүүлэхээр гэрээнд тусгасан байна.

2.3 Үндсэн хөрөнгийн элэгдлийг 4,126.5 мянган төгрөгөөр илүү тооцсон, бараа материалын анхан шатны маягтуудыг бүрэн хөтлөөгүй байна.

Аймгийн Татварын хэлтэс 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 82,242.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 7,630.1 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Тус хэлтсийн үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэл, тайлагнал, анхан шатны баримтын бүрдэлд хийсэн шалгалтаар дараах зөрчил дутагдлууд илэрлээ. Үүнд:

- 2015 оны жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй бөгөөд хэлтсийн даргын 2016 оны 05 дугаар сарын 18-ны А/22 дугаар тушаалаар комисс томилж 2015 оны жилийн эцсийн тооллого хийсэн,
- Нягтлан бодогч солигдоход эд хөрөнгийн тооллого хийгээгүй,
- Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцохдоо НБББББ-т заасан хугацааг мөрдөж ажиллаагүйгээс тоног төхөөрөмжийн 47 ширхэг 35,835.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглах жилийг 3 жилээр тооцсоноос үндсэн хөрөнгийн элэгдлийг 4,126.5 мянган төгрөгөөр илүү бүртгэж, тайлагнасан,
- Бараа материалын тайланг үнийн дүнгүй зөвхөн орлого, зарлагын тоо хэмжээг бичиж тайлагнасан боловч агуулахын бүртгэл болон бараа материалын дэлгэрэнгүй тайлан, бараа материалын орлого, зарлагын түүвэр зэргийг нярваар гаргуулаагүй,

- Бараа материалыг орлого авахдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагын зарлагын баримт дахь тоо, үнийн дүнг зөрүүтэй бүртгэсэн байна.

Эдгээр нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-т "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2.2-т "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", ТЕГ-ын даргын 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 104 дүгээр тушаалаар баталсан "Үндэсний татварын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим"-ын 4 дүгээр бүлгийн 4.3.2.2-т "Бараа материалтай холбоотой ажил гүйлгээг бүртгэхэд дараах анхан шатны баримтад үндэслэнэ", 4.4.8 буюу 71 дүгээр хуудсанд "Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцоходоо Засгийн газрын 2015 оны 233 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам", "Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ"-г дагаж мөрдөнө" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд үндсэн хөрөнгийн элэгдлийг НБББББ-ийн дагуу үнэн зөв тооцож бүртгэх, тоног төхөөрөмжийн 4,126.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг 2016 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар залруулах албан шаардлага, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг улирал бүрээр архивлаж, бараа материалын анхан шатны маягтуудыг бүрэн хөтлөх, нярвын тайланг бүрэн гаргуулах талаар зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.4 Удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас НБББББ-ийг мөрдөж ажиллаагүй, албан хэрэг хөтлөлт хангалтгүй байна.

Аймгийн Татварын хэлтэс нь "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах комисс"-ыг хэлтсийн даргын 2016 оны 06 дугаар сарын 08-ны А/26 дугаар тушаалаар томилсон байна.

Тус хэлтсийн "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах комисс" нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан бөгөөд 2016 оны 3 дугаар улирлын байдлаар 2 удаа хэлтсийн даргаар удирдамж батлуулан хяналт, шалгалт хийсэн байна.

Тус комисс нь дотоод баримт бичгийн бүртгэл хөтлөлт, өөрт холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, тушаалыг хяналт авсан байдал, судалгаа гаргасан байдал, ажлын төлөвлөлт, тайлагналт, үнэт цаасны ашиглалт, зарцуулалт, тооцоо бодолт, ажлын цаг ашиглалт, санхүүгийн үйл ажиллагаа гэсэн сэдвээр шалгалт хийж холбогдох зөвлөмжүүдийг өгсөн боловч зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал: Тус хэлтсийн хуулийн зөвлөх нь "Дотоод хяналт, шалгалт зохион байгуулах комисс"-ын даргаар томилогдсон бөгөөд хэлтсийн даргын тушаалыг

боловсруулахдаа тушаалын үндэслэл буруу, холбогдох журмыг баталсан шийдвэрийн дугаарууд болон ур чадварын нэмэгдэл олгосон тушаалын хавсралт, санхүүгийн баримтад хавсаргасан тушаалын хавсралт зөрүүтэй, 2015 оны жилийн эцэст болон нягтлан бодогч солигдоход эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна.

Мөн нягтлан бодогч нь албан хэрэг хөтлөлтийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд ирсэн, явуулсан албан бичгийг бүртгэлийн дэвтэрт өөр өнгийн балаар бүртгэсэн, албан бичгийн утгыг товчилж, гадаад үсгээр орлуулан бичсэн зэрэг зөрчил дутагдлууд нь Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ыг зөрчсөн байна.

Дээрх зөрчлүүд нь тус байгууллагын удирдлагаас ажилтнуудыг холбогдох зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллаагүйтэй холбоотой бөгөөд Монгол улсын НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно” гэснийг зөрчсөн байна.

Иймд даргын тушаалыг үндэслэлтэй боловсруулах, албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу хөтлөх, мөн эд хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийж гүйцэтгэх зэрэг зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

2.5 Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг оруулахдаа батлагдсан төсвийг мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг төгрөгөөр мэдээлсэн нь хэтрэлт, хэмнэлтийг тооцоолох боломжгүй болсон байна.

Тус хэлтэс шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэстэй бөгөөд Төсөв/гүйцэтгэл хэсгийн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр) цэсэнд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн 12 мэдээллийг оруулсан бөгөөд 1, 3 дугаар сарын мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Мөн мэдээллийг оруулахдаа төсвийг мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн дүнг төгрөгөөр мэдээлсэн нь хэтрэлт, хэмнэлтийг тооцоолох боломжгүй болсон байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг сар бүр бүрэн мэдээлсэн байна.

Иймд төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн төсвийн дүнг төгрөгөөр болгож залруулах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Аудитаар нийт 273,985.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 577.1 мянган төгрөгийн акт тогтоож, 10,257.2 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 263,151.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Орон нутгийн татварын 10 нэр төрлийн орлого 0.3-53.0 хувиар тасарсан байна.
2. Орлогын дансдын залруулгыг цаг тухай бүрд хийгээгүйгээс 56,948.1 мянган төгрөгийн орлогыг буруу бүртгэж, мэдээлсэн байна.
3. Арилжааны банкуудад татварын орлогын дансдыг нээхдээ Сангийн сайдын баталсан Арилжааны банкны гурван талт “Арилжааны банкинд төсвийн орлогын “ТЭГ” үлдэгдэлтэй дансдыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ”-ний загвараар байгуулаагүй байна
4. Татварын мэдээллийн санд 56,948.1 мянган төгрөгийн татварын орлогыг нэр төрлөөр нь зохих журмын дагуу бүртгээгүй байна.
5. Орон нутгийн татварын орлогыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэстэй 1, 7 дугаар саруудад тооцоо нийлж баталгаажуулаагүй, сар бүрийн орлогын мэдээ зөрүүтэй байна.
6. Батлагдсан төсвийг хэтрүүлэн зориулалт бусаар 6,130.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.
7. Үндсэн хөрөнгийн элэгдлийг 4,126.5 мянган төгрөгөөр илүү тооцсон, бараа материалын анхан шатны маягтуудыг бүрэн хөтлөөгүй байна.
8. Удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас НБББББ-ийг мөрдөж ажиллаагүй, албан хэрэг хөтлөлт хангалтгүй байна.
9. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг оруулахдаа батлагдсан төсвийг мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг төгрөгөөр мэдээлсэн нь хэтрэлт, хэмнэлтийг тооцоолох боломжгүй болсон байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Татварын хэлтсийн даргад:

1. Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг тухайн жилд бүрдүүлэх боломжтой эсэхийг бүрэн тооцож бодит тоон мэдээнд үндэслэн батлуулах
2. Тээврийн хэрэгслийн тоог АТҮТ-тэй тулган баталгаажуулах, бүртгэгдээгүй тээврийн хэрэгслийг бүртгэх, хуулийн дагуу татварыг ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой, хамтран ажиллах,
3. Хөдөлгөөнд оролцоогүй тээврийн хэрэгслийн албан татварыг АТҮТ-ийн бүртгэлээс хасагдаагүй тохиолдолд хуулийн дагуу төсөвт төвлөрүүлж байх,
4. Сангийн сайдын баталсан Арилжааны банкны гурван талт “Арилжааны банкинд төсвийн орлогын “ТЭГ” үлдэгдэлтэй дансдыг нээх, түүний төлбөр тооцоог зохицуулах гэрээ”-ний загварын дагуу арилжааны банкуудтай гэрээг шинэчлэн байгуулах, татварын орлогын “0” үлдэгдэлтэй дансдын нэр төрлийг цөөрүүлэх, холбогдох журмын дагуу өдөр тутмын орлогыг хаалтын дансанд төвлөрүүлж байх, шаардлагагүй дансдыг хааж, цэгцлэх
5. Татварын орлогын мэдээллийг програмд оруулахдаа татварын нэр төрлийн ангилал, татвар төлөгчийн мэдээллийг үнэн зөв бүртгэх
6. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах, төсвийг зориулалтын дагуу зарцуулах, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх, хөрөнгийн болон урсгал шинжтэй үйл ажиллагаанд зарцуулахгүй байх тухай
7. Татварын орлогыг сар бүр тооцоо нийлж баталгаажуулах
8. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг улирал бүрээр архивлаж, бараа материалын анхан шатны маягтуудыг бүрэн хөтлөх, нярвын тайланг бүрэн гаргуулах
9. Даргын тушаалыг үндэслэлтэй боловсруулах, албан хэрэг хөтлөлтийг холбогдох журмын дагуу хөтлөх, мөн эд хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу хийж гүйцэтгэх
10. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, гүйцэтгэлийн мэдээллийн төсвийн дүнг төгрөгөөр болгож залруулах

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад:

1. Орон нутгийн татварын орлогын дансанд залруулга хийсэн эсэх талаар аймгийн Татварын хэлтэст албан ёсоор хариу хүргүүлж байх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ

Аймгийн Татварын хэлтсээс ирүүлсэн санал:

419.


**ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ТАТВАРЫН ХЭЛТЭС**
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, Чойр, 3 дугаар баг,
Утас/Факс: (976) 7054 3185

2016-12-07 № 01/597
танай 2016-12-06-ны № 268-т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Тус хэлтсийн 2016 оны эхний 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагааны үр дүн болон орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд хийсэн завсарын аудитын тайлангийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлэв.
Хавсралт: 7 хуудас

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  П.ЭНХ-ОЮУН

Б. Сарантүвшин
Хайлбартай
танилцан танил
орчуулах. ттх.
туран саналыг
танилцуулав
2017/01/15

Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн 2016 оны
12 дугаар сарын 07-ны өдрийн 22 тоотын хавсралт

ЗАВСРЫН АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ



1. 2016 оны 1-3 дугаар улиралд тухайн байгууллагын төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т “төсвийг тогтоосон ангилалын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.”, 41 дүгээр зүйлийн 41.2-т “бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ.”, 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.4-т “төсвийн сар улирлын хуваарийг баримталж ажиллах” гэсэн заалтуудыг зөрчиж татварын улсын (ахлах) байцаагч нарт олгох сарын ажлын үр дүнгийн урамшууллын төсвөөс /за-210104/ төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг олгосон байна. (Ур чадварын нэмэгдлийн төсөв нь үндсэн цалингийн зардлын төсөвт тусгагдаг. /за-210101/)

Иймд, Төсвийн тухай хуулийн 70.4.6-д “энэ хуулийн 30.3, 39.4, 41.2, 42.2, 43 дугаар зүйл, 50.1, 50.2, 51.2, 65.1.6, 66.1.5-д заасныг зөрчсөн албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох,” гэж заасны дагуу төсвийн шууд захирагчид (С.Алтанцэцэг) нь хариуцлага тооцож, Татварын албанд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний /татвар хураагч, эдийн засагч, хуулийн зөвлөх/ албан хаагчид нь улсын болоод орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэхэд бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж, 2016 оны жилийн Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг ханган биелүүлж байгаа байдлыг харгалзан үзэж албан хаагчдаар төлүүлэхээр тогтоосон хоолны нэмэгдэл болон ур чадварын нэмэгдлийн “акт”-ыг “зөвлөмж” болгон өөрчилж өгнө үү.

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4-р хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д зааснаар “Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэт арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан, эсвэл гоц авьяастай ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.”, “Ур чадварын нэмэгдлийг тухайн салбар, байгууллагын үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулдаг мэргэжлийн албан хаагчид олгоно.” гэсэн заалтуудыг үндэслэн төрийн үйлчилгээний ажилтануудын ажлыг үнэлж дүгнэсэн байдал хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энэхүү зөрчлийг төрийн үйлчилгээний албан хаагчдын 2016 оны 1-9 дүгээр саруудын ажлын гүйцэтгэлтэй уялдуулан дахин үнэлж, дүгнэн 2017 оны 1-р улиралд багтаан залруулж, танай байгууллагад хариу хүргүүлэх болно.

Хэрэв, дээрх төрийн үйлчилгээний албан хаагчдад олгосон ур чадварын нэмэгдэл болон хоолны нэмэгдлийг актаар буцаан төлүүлэх нь үндэслэлтэй гэж үзвэл дээрх хөнгөлөлт, нэмэгдлийг олгох шийдвэр гаргасан төсвийн шууд захирагчаар нь актыг төлүүлэхээр дүгнэлтээ өөрчилнө үү.

2. Татварын албаны AUTOTAX программ нь Автотээврийн үндэсний төвийн бүртгэлийн VRS программтай холбогдсон бөгөөд тээврийн бүртгэл, хэрэгслийн хасалт, шилжилт хөдөлгөөн нь зөвхөн Автотээврийн үндэсний төв дээр хийгддэг бөгөөд тэрхүү бүртгэлд хийгдсэн өөрчлөлтүүд нь

Татварын албаны AUTOTAX программ руу хөрвөж, АТҮТ болон Татварын албаны мэдээллийн бааз холбогдон ажилладаг.

2016 оны 11 дүгээр сарын 31-ний байдлаар Автотээврийн үндэсний төвийн бүртгэлийн VRS программтай холбогдсон татварын Autotax программ дахь Говьсүмбэр аймагт бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо 3038 байсан бөгөөд хөдөлгөөнд оролцох боломжгүй, ашиглах боломжгүй зэргээр Автотээврийн хэрэгслийн бүртгэлтээс хасуулахаар 2016 оны АТБӨЯХэрэгслийн үзлэг, оношлогоо, татвар хураах ажлын явцад өргөдөл, хүсэлтээ өгсөн 572 тээврийн хэрэгслийн жагсаалт, холбогдох баримтыг бүрдүүлэн аймгийн Автотээврийн төвөөс АТҮТөв рүү хүргүүлсэн ба эдгээрээс одоогийн байдлаар буюу 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар 273 тээврийн хэрэгсэл хасагдаж бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 2765 болсон байна.

Үлдэх хасуулахаар хүргүүлсэн тээврийн хэрэгслийг энэ онд АТҮТ-өөс бүрэн хасалт хийж дуусахад тухайн тээврийн хэрэгслийн түүх болон ногдол, төлөлт зэрэг мэдээлэл нь АТҮТ-ийн бүртгэлийн VRS программд устаж, улмаар уг мэдээлэл нь татварын албаны AUTOTAX программ руу хөрвөж ордог.

Иймд, 2016 оны 3-6 сард явагдсан АТБӨЯХэрэгслийн үзлэг, тооллого, 2016 оны 8-9 сард хийгдсэн хяналтын үзлэг, тооллогын үеэр иргэдээс тээврийн хэрэгсэл бүртгэлтээс хасуулах өргөдөл, хүсэлтийг хүлээн аваад, шийдвэрлээгүй хугацаа алдсан асуудал байгааг үгүйсгэхгүй бөгөөд төрийн байгууллагын хариуцлагагүй байдлаас шалтгаалан иргэдэд чирэгдэл учруулан тээврийн хэрэгслийн татварыг нөхөн авах нь зохисгүй байдлыг харгалзан “орон нутгийн төсөвт 28,6 сая төгрөгийн АТБӨЯХАТ, агаарын бохирдлын төлбөрийг нөхөн төшлөрүүлэх” гэсэн зөвлөмжийг өөрчлөн, уг асуудалд хариуцлагагүй хандан тухайн үед ажиллаж байсан холбогдох агентлагын дарга нарт нь хариуцлага тооцохоор оруулж өгнө үү.

Аудитын дүгнэлтийн бусад хэсэгт ямар нэгэн санал хүсэлт байхгүй бөгөөд Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлуудыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах болно.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
АВТОТЭЭВРИЙН ТӨВ

42017 Говьсүмбэр аймаг, Сүмбар-сүм, 2 дугаар баг
Утас: 7054 3453

2016-12-12 № 121

танай _____ -ны № _____ -т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТАТВАРЫН ХЭЛТЭСТ

Тус байгууллагын бүртгэлийн программд
2016 оны 12 сарын 12-ны өдрийн байдлаар
2900 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байна.

Хүндэтгэсэн:

ДАРГА



Ж.НАСАНБАТ

БАТЛАВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Ш БИЛЭГГҮМБЭРЭЛ

АТБӨЯХАТ, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, албан татварт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг татвар, техникийн хяналтын үзлэгт хамруулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар зохион байгуулж буй ажлын

НЭГДСЭН УДИРДАМЖ

2016-08-30

Говьсүмбэр аймаг

Зорилго: Автотээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татварын хууль болон Автотээврийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг болон албан татварт хамруулах, зөрчлийг арилгуулах, бүртгэл баазыг цэгцлэх

Хугацаа: 2016-08-30-ны өдрөөс 2016-09-20-ны өдөр

Хамтран зохион байгуулах байгууллага: Татварын хэлтэс, Авто тээврийн төв Цагдаагийн хэлтэс, Сүмбэр, Шивээ-говь, Баянтал сумдын ЗДТГазар

Хийх ажлын удирдлага, зохион байгуулалт: Аймгийн Цагдаагийн хэлтэс, Татварын хэлтэс, Авто тээврийн төвийн удирдлагууд хяналт тавьж, нэгдсэн удирдамжин даг ажуудыг хийж гүйцэтгэнэ.

Бэлтгэл үйл ажиллагаа: Аймгийн хэмжээнд нэгдсэн байдлаар зохион байгуулж нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Нэгдсэн удирдамж, төлөвлөгөө, төсвийг гаргах
- Сумдын ЗДТГ, багийн Засаг дарга нараас техникийн хяналтын үзлэг, татвар хамрагдаагүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн мэдээллийг /ажлын болон гэрийн хаяг байршил, холбогдох утас/нарийвчлан гаргуулах, холбоо тогтоох
- Үйл ажиллагааны явцад хамтран ажиллах байгууллага, албан тушаалтны жагсаалтыг гаргах
- Гарын авлага бэлтгэх/оролцож буй байгууллагууд өөрсдийн ажилтай холбоотой/

Байгууллагуудаас хийгдэх үйл ажиллагаа:

1. Техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй, АТБӨЯХАТ-аа төлөөгүй тээврийн хэрэгслийн Татварын албаны судалгаа, Авто тээврийн үндэсний төвийн судалгааг тулг баталгаажуулж хоорондын зөрчил, зөрүүг арилган тодорхой болгох
2. Судалгааг 3 сумын ЗДТГазарт хүргүүлж, тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрийн болон ажлын хаяг, бусад холбогдох мэдээллийг харъяалах багийн Засаг дарга нараар хянуул тодруулан нарийвчлан гаргах
3. Тодорхой болсон тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хаягаар /ажлын болон гэрийн/ оролцож зөрчлийг арилгуулах, багийн засаг дарга нараар утасдуулж шаардлага тавиул татварт хамруулах

4. Зөрчилтэй /үзлэг, оношлогоо, татварт хамрагдаагүй/ тээврийн хэрэгслийн бичиг баримт түдгэлзүүлэн, зөрчил арилгасны дараа эзэмшигчид олгох
5. Замын цагдаагийн тасгийн авто тээврийн хэрэгсэл хариуцсан цагдаа, АТҮТ-ийн тээврийн хяналтын байцаагч, Татварын хэлтсийн авто тээвэр хариуцсан байцаагч н /байгууллагаас томилогдсон ажилтнууд/ хамтран 4 замын уулзвар, цагдаагийн пост г мэт тээврийн хэрэгсэл их зорчдог газруудад эргүүл шалгалтыг /удирдамжийн хугацаа өдөр бүр/ хийх
6. Татварт хамруулах
7. АТӨЯХАТ-ын болон авто тээврийн тухай хуулийг сурталчилах

Үйл ажиллагааны үр дүнг тайлагнах:

Зохион байгуулсан ажлын тайлан, үр дүнг томилогдсон ажилтнууд байгууллаг удирдлагуудад 9 сарын 25-ны дотор тайлагнах.

Удирдамж боловсруулсан:

Татварын хэлтэс, Авто тээврийн тсв, Цагдаагийн хэлтэс.

АТӨЯХАТ, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, албан татварт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг татвар, техникийн хяналтын үзлэгт хамруулах, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар зохион байгуулж буй ажлын

Тайлан

2016-09-22

Говьсүмбэр аймаг

2016-08-30-ны өдрөөс 2016-09-20-ны өдрийн хооронд Аймгийн засаг даргын орлогч Ш.Билэгтүмбэрэлээр батлуулсан нэгдсэн удирдамжын дагуу зохион байгуулагдсан арга хэмжээний хүрээнд Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн ЗЦТ-ын хөдөлгөөн зохицуулагч, АТҮТөвийн тээвэр зохицуулагчтай хамтран Сүмбэр сумын нутаг дэвсгэрт (Замын баруун талд мөн 4-н замын уулзвар, хэлмэгсдийн хөшөөний уулзвар, ЗЦ-ын пост г.м тээврийн хэрэгсэл их зорчдог газруудад) эргүүл шалгалтыг хийсэн. Шивээговь сум, Баянтал сумуудруу шалгалтаар очиж ажилласан.

Судалгааг сум, багийн засаг дарга нарт хүргүүлж, тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрийн болон ажлын хаяг, бусад холбогдох мэдээллийг хариутай бичгээр хүлээн авч ажилласан. Сум, багийн засаг дарга нарын сударгааг үндэслэн

- Сүмбэр сумын татвар төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд рүү багийн засаг дарга нараар
- Шивээговь сумын татвар төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд рүү ШГСумын Цагдаагийн тасагын автын байцаагчаар
- Баянтал сумын татвар төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэд рүү БТСумын цагдаагийн тасгийн цагдаагаар

Тус тус утсаар мэдэгдсэн.

Мөн судалгааг үндэслэн татвар төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрт нь болон ажлын газраар нь очиж уулзсан.(Үүнд: ЗЦТ-ын цагдаа, Татварын хэлтсийн байцаагч, АТҮТ-н тээвэр зохицуулагч нар хамтран ажилласан.)

73-н айл өрхөөр явж татвараа төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигч иргэнтэй уулзаж татвар төлүүлэх, тээврийн хэрэгслийг хэрхэн хасалт хийх талаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

АТӨЯХАТ татвараа төлөөгүй аж ахуй нэгж байгууллагуурууд албан тоотоор хандаж зохих арга хэмжээг авч ажилласан.

Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 33-н тээврийн хэрэгслийн 1,947,970 төгрөгийн АТӨЯХАТ, АБТ, АЗАТ-ийг нөхөн төлүүлж улс болон орон нутгийн дансанд төвлөрүүлсэн. Татвараа төлсөн баримтыг үндэслэн гэрчилгээн дээр бичилт хийн программд бүртгэсэн.

Тайлан гаргасан: Автын татвар хариуцсан хураагч

/М.Буяндэлгэр/

Хийгдсэн ажлын хүрээнд гарсан зардал

№	Явсан газрууд	Хугацаа, явсан км	Түлш зарцуулалт	Нийт дүн
1	Сүмбэр сумын нутаг дэвсгэрт (Замын баруун талд мөн 4-н замын уулзвар, хэлмэгсдийн хөшөөний уулзвар, ЗЦ-ын пост г.м тээврийн хэрэгсэл их зорчдог газруудад) эргүүл шалгалтыг хийсэн. Татвар төлөөгүй тээврийн хэрэгсэл эзэмшигчийн гэрээр явж ажилласан	14хоног, өдөрт 50 км нийт 700км	105л	177.450
2	Шивээговь сумруу шалгалтаар очиж ажилласан.	1хоног 150км	22.5л	44.100
3	Баянтал сумруу шалгалтаар очиж ажилласан.	1хоног 88км	13.2л	22.350
				243.900

Задаргаа гаргасан:

Говьсүмбэр аймгийн Татварын хэлтсийн АТБӨЯХАТ-н хураагч



/М.Буяндэлгэр/

Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн ЗЦТ-н ахлах дэслэгч

/Р.Одбаяр/

Тайлбар

Авто тээврийн үндэсний төвийн бүртгэлийн программ болон Татварын сренхий тазрын "AutoTax" программ хоорондын зөрүү нь тухайн онд шилжиж ирсэн болон шилжин явсан тээврийн хэрэгслийн тоогоор зөрлөг. Тухайлбал АТУТөвийн бүртгэлийн программ тухайн иргэний шилжилт хөдөлгөөнөөр шууд хийгдэж бүртгэл хийгддэг. ТEG-ын "AutoTax" программ нь тухайн оны буюу 2016.02.19-нд Улс даяар тээврийн хэрэгслийн ногдолыг ТEG-с үүсгэдэг. Тээврийн хэрэгсэл шилжилт хөдөлгөөн хийсэн ч ногдол үүссэн албаараа буюу татвар төлөх газраараа дуудлагддаг. Иймд 2 байгууллагын бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоонд зөрүү үүсдэг.

Тайлбар гаргасан: АТБӨЯХАТ хариуцсан

хураагч:  М.Буяндэлгэр/

Тайлбар

2016 оны 11 дүгээр сарын 30-ний байдлаар Авто тээврийн үндэсний төвтэй холбогдсон татварын AutoTax программ дахь Говьсүмбэр аймагт бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийн тоо 3038 байсан бөгөөд хөдлөгчид орохоо больсон, ашиглах боломжгүй зэргээр Авто тээврийн хэрэгслийн бүртгэлээс хасуулахаар өргөдөл өгсөн 572 иргэний 572 тээврийн хэрэгслийн жагсаалт, холбогдох баримтыг бүрдүүлэн аймгийн Авто тээврийн төвөөс АТУТөв рүү хүргүүлсэн ба эдгээрээс одоогийн байдлаар буюу 2016 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар 273 тээврийн хэрэгсэл хасагдаж бүртгэлтэй тээврийн хэрэгслийн тоо 2765 болсон байна. Үлдэх 299 хасуулахаар хүргүүлсэн тээврийн хэрэгслийг энэ онд АТУТ-с бүрэн хасалт хийх тул дээр хасагдсан тээврийн хэрэгслүүдийн түүх болон ногдол AutoTax программаас автоматаар хүчингүй болдог. Иймд хасагдаж байгаа тээврийн хэрэгсэлээ татвар нөхөн түлүүлэх боломжгүй /татаараа төлөөд хасалтаа хийлгэхээр хүтээгдэж байгаа учраас, хасалт хийх хугацаа улаанирсантай холбоотой/.

Тайлбар гаргасан: АТБӨЯХАТ хариуцсан

хураагч:  М.Буяндэлгэр/

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР

Танай байгууллагаас ирүүлсэн албан бичигтэй танилцаад дараахь тайлбарыг хийж байна.Үүнд:

1. Аймгийн хэмжээнд 572 тээврийн хэрэгсэл Автотээврийн үндэсний төвөөс хасалт хийгдэж байгаатай холбоотойгоор тухайн онд ногдуулсан орлого болон тухайн тээврийн хэрэгслийн бүх мэдээлэл устаж байгаагаас шалтгаалан 28.6 сая төгрөгийн АТБӨЯХАТ болон агаарын бохирдлын төлбөрийн орлого төвлөрөх боломжгүй гэсэн тайлбар ирүүлсэн байна. Иймд Хөдөлгөөнд оролцоогүй тээврийн хэрэгслийн албан татварыг АТҮТ-ийн бүртгэлээс хасагдаагүй тохиолдолд хуулийн дагуу төсөвт төвлөрүүлж байх зөвлөмж өгөв.
2. Төрийн захиргааны албан тушаалд түр хугацаагаар томилогдон төрийн үйлчилгээний албан тушаалын сүлжээгээр цалинжиж байгаа албан тушаалтнуудад олгосон хоолны болон ур чадварын нэмэгдэлд тогтоосон төлбөрийн актыг зөвлөмж болгуулах санал ирүүлсэн байна. Энэ нь тушаалын үндэслэл буруу, батлагдсан төсвийг хэтрүүлэн зориулалт бусаар зарцуулсан тул дээрх зөрчлийг арилган, давтан гаргахгүй байх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.